

**АРХАНГАЙ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ,
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2022 ОНЫ 10 ДУГААР
САРЫН АЖЛЫН МЭДЭЭ**

Нэг. Удирдлага, зохион байгуулалтын талаар

**Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын албаны
үйл ажиллагааны мэдээлэл**

Аймгийн ИТХ-ын ээлжит 8-р хуралдаан 2022 оны 09-р сарын 30-ны өдөр 100 хувийн ирцтэйгээр хуралдаж аймгийн Засаг даргыг огцруулах тухай, нутгийн өөрөө удирдах байгууллага үүсч хөгжсөний 30 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх тухай, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай, Архангай аймгийн хөгжлийн 2023 оны жилийн төлөвлөгөө батлах тухай асуудлуудыг хэлэлцэн шийдвэрлэлэсэн.

Аймгийн ИТХ-ын ажлын албанаас “Төлөөлөгчийн нэг өдөр”- арга хэмжээг Хангай, Хашаат, Жаргалант, Өлзийт сумдад зохион байгуулж тус сумаас сонгогдсон төлөөлөгч, хурлын ажлын албаны ажилтнууд нар сумын ИТХ-ын дарга, нарийн бичгийн дарга нарын ажил байдалтай танилцаж, арга зүйн зөвлөгөө өгч ажилласан байна.

Аймгийн Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны мэдээлэл

2022 оны 10 дугаар сарын 25-ны өдөр аймгийн удирдах ажилтны шуурхай зөвлөгөөнийг зохион байгуулж 9 дүгээр сард өгсөн үүрэг даалгаврын биелэлт, үр дүнг танилцуулж, Архангай аймаг дахь Цагдаагийн газар, Онцгой байдлын газар, Эрүүл мэндийн газраас цаг үеийн ажил, анхаарах асуудлын талаар мэдээлэл хийж аймгийн удирдлагууд удирдах ажилтнуудад үүрэг даалгавар, цаашид анхаарах ажлын чиглэлийг өглөө.

Төрийн албаны ерөнхий шалгалтыг 2022 оны 10 дугаар сарын 14-ний өдрийн 08.00-21.10 цагт холбогдох хууль, журмын дагуу зохион байгууллаа. Архангай аймагт төрийн албаны ерөнхий шалгалт өгөхөөр нийт 157 иргэн бүртгүүлснээс, 131 иргэн шалгалтад орсон, 26 иргэн шалгалтад ороогүй, ерөнхий мэдлэгийн шалгалтад 57 иргэн, монгол хэл бичгийн шалгалтад 50 иргэн, дүн шинжилгээ хийх чадварын шалгалтад 46 иргэн тус тус тэнцэж, нийт шалгалтад оролцогчдын 35.1 хувь буюу 46 иргэн төрийн албаны ерөнхий шалгалтад тэнцсэн.

Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн дагуу Архангай аймгийн 2023 оны хөгжлийн жилийн төлөвлөгөөг боловсруулан, Эдийн засгийн хөгжлийн яаманд хянуулж, хуулийн хугацаанд нь аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлууллаа.

Монгол Улсын Шадар сайд аймгийн Засаг даргатай 2022 онд байгуулсан гэрээний дагуу энэ онд Архангай аймгийн Цэцэрлэг, Жаргалант, Эрдэнэмандал, Хайрхан, Булган, Эрдэнэбулган, Цахир, Өндөр-Улаан, Хангай, Чулуут, Тариат, Хашаат гэсэн 12 суманд гамшгаас хамгаалах бэлэн байдлын үзлэг зохион байгуулсан.

Архангай аймагт 2022 оны 2-р ээлжийн цэрэг татлагыг 2022 оны 09 дүгээр сарын 25-наас 10 дугаар сарын 15-ны өдрүүдэд зохион байгууллаа.

“Хөдөө аж ахуйн салбарын 2022-2023 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2022 оны 277 дугаар тогтоол, “2022-2023 оны өвөлжилт, хаваржилтийн болон ургац хураалтын бэлтгэл хангах тухай” Ерөнхий сайдын 2022 оны 09 дүгээр албан даалгавар, “Өвөлжилийн бэлтгэл хангах зарим арга хэмжээний тухай” аймгийн Засаг даргын 2022 оны 04 дүгээр албан даалгаврыг сум, байгууллагын удирдлагуудад хүргүүлж, хөдөө аж ахуйн салбарын болон төв суурин газрын өвөлжилтийн бэлтгэл ажил, цаг үеийн нөхцөл байдалтай газар дээр нь танилцах ажлын хэсгүүд сум, байгууллагуудад ажиллаж хугацаатай үүрэг даалгавар, зөвлөмж, чиглэл өгч, хэрэгжилтэд хяналт тавин ажилласнаар өвөлжилтийн бэлтгэл хангуулах ажлыг аймгийн хэмжээнд 91.2 хувьтай хангасан байна.

Архангай аймгийн Төрийн архивын тасаг нь иргэн хуулийн этгээдэд төрийн архивын үйлчилгээг хөнгөн шуурхай, хүртээмжтэй хүргэх зорилтын хүрээнд 72 м² талбай бүхий үйлчилгээний заал, ажилчдын өрөөг засварлан тохижуулж, 9,9 сая

төгрөгийн техник хэрэгслээр ханган ажиллах, иргэдэд үйлчилгээ үзүүлэх нөхцөл боломжийг сайжрууллаа.

Цахим шилжилт

Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгасан “Цахим Архангай” төрийн шуурхай үйлчилгээг нэвтрүүлэх зорилтын хүрээнд Цахим хөгжил, харилцаа холбооны яамны зөвлөмжийн дагуу “Цахим аймаг” хөтөлбөрийн төслийг боловсруулж, хөтөлбөрийн зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгчээр “Ай Си Ти групп” ХХК шалгарч, гүйцэтгэгчтэй 1.4 тэрбум төгрөгийн өртөгтэй гэрээ байгуулан хамтран ажиллаж байна.

“Цахим Архангай” хөтөлбөрийн хүрээнд аймгийн Нэгдсэн эмнэлэг, 19 сумын Эрүүл мэндийн төв, 33 ерөнхий боловсролын сургууль, 19 сумын Засаг даргын тамгын газар, аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний 28 агентлагт удирдлага, зохион байгуулалталтын цахим шийдэл, аймгийн нэгдсэн болон 19 сумын цахим хуудсыг шинэчлэх, хөрөнгө оруулалтын удирдлагын цахим шийдэл, аймгийн орон зайн мэдээллийн систем, автомат шалган нэвтрүүлэх цахим шийдэл, аймгийн иргэдэд зориулсан нэгдсэн гар утасны аппликейшн зэрэг системүүдийг үе шаттайгаар нэвтрүүлэх бөгөөд 2022 оны 9 дүгээр сарын 05-наас 07-ны өдрүүдэд гүйцэтгэгч компанийн төлөөлөл Архангай аймагт ажиллаж ажлын даалгаварт тусгах саналыг боловсруулж 2022 оны 12 дугаар сарын 15-ны дотор дээрхи системүүдийг бүрэн ашиглалтад оруулахаар ажиллаж байна.

ХУР, ДАН системээр иргэдэд нийт 61 байгууллагын 660 төрлийн үйлчилгээг цахимаар үзүүлж байгаа бөгөөд Архангай аймгийн нутгийн захиргааны 13 байгууллагын 51 үйлчилгээ шинээр "e-mongolia" системд нэмсэнээр орон нутгийн оператор ажилтнуудаар дамжуулан нийт 211 үйлчилгээг цахимаар үзүүлж байна.

Сумдад төрийн цахим үйлчилгээг нэвтрүүлэх төслийн хүрээнд Архангай аймгийн Тариат, Өндөр-Улаан, Ихтамир сумдад 20 м өндөртэй харилцаа холбооны цамхаг угсарч суурилуулах, Цэнхэр, Хашаат сумдад үйлчилгээний нэгдсэн төвийн шинэ барилга барих ажлууд хийгдсэн.

Мөн хөдөөгийн алслагдсан багуудыг холбоожуулах, 4G сүлжээний үйлчилгээ хүргэх төслийн хүрээнд Өндөр-Улаан сумын Азарга баг, Ихтамир сумын Бугат, Хөхнуур баг, Тариат сумын Алтаад багуудад холбогдох дэд бүтцийн ажлууд хийгдэж байна.

Жаргалант сумын алслагдсан Зуслан багийн “Зуслангийн магнай” гэх газарт Юнителийн 4G сүлжээний станц ашиглалтад орлоо.

Хоёр. Эдийн засаг, төсөв, санхүүгийн бодлогын хүрээнд

Төсвийн орлого

2022 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн байдлаар улсын төсвийн орлогод өссөн дүнгээр 2,276,397,645.3 мянган төгрөг төвлөрүүлэхээс 2,036,989,007.1 мянган төгрөг төвлөрүүлж, төлөвлөгөөний биелэлт 89.5 хувь, аймгийн төсвийн орлогод өссөн дүнгээр 1,780,549,600.0 мянган төгрөг төвлөрүүлэхээс 1,826,276,551.4 мянган төгрөг төвлөрүүлж, биелэлт 102.6 хувь, сумын төсвийн орлогод өссөн дүнгээр 11,504,563.0 мянган төгрөг төвлөрүүлэхээс 12,072,510.0 мянган төгрөг төвлөрүүлж, биелэлт 104.9 хувь байна.

Тендер, худалдан авах ажиллагаа

2022 онд улс, орон нутгийн төсөв, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх 123706.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 88 төсөл арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахаар төлөвлөгөөг баталсан. Улсын төсвийн хөрөнгөөр шинээр хэрэгжүүлэх 116751.2 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 30 төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааны эрхийг аймгийн Засаг даргад шилжүүлсэн. Төсвийн тодотголоор 700.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 2 төсөл арга хэмжээ хасагдсан.

2022 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн байдлаар 350.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 1 төсөл арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийг 3

удаа зарласан боловч оролцогч байхгүй байна. Ажлын даалгаварт өөрчлөлт оруулж тендерийг дахин зарлахаар бэлтгэж байна. Үлдэх 122656.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 85 төсөл арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгож гэрээг байгуулсан байна.

Хөрөнгө оруулалт

2022 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар нийт 81,527,8 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 55 төсөл арга хэмжээ, аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 3,704,9 сая төгрөгийн 24 төсөл, арга хэмжээ, орон нутгийн хөрөнгөөр хийгдэх их засвараар 1,100,0 сая төгрөгийн 11 төсөл арга хэмжээ тус тус хэрэгжихээр батлагдсанаас 2022 оны эхний 10 сарын байдлаар улсын төсвийн хөрөнгөөр 12,983,4 сая төгрөгийн, Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 1,312,3 сая төгрөгийн, орон нутгийн хөрөнгө оруулалтаар хийгдэх их засвараар 905,6 сая төгрөгийн санхүүжилт тус тус хийгдсэн.

Санхүүгийн хяналт

Өндөр-Улаан сумын төсөвт албан байгууллагуудад хийгдсэн дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалтаар нийт 103.7 сая төгрөгийн зөрчил илрүүлснээс 7.7 сая төгрөгийн нөхөн төлбөрт улсын байцаагчийн акт, 90.1 сая төгрөгийн дүн бүхий зөрчил арилгуулах хугацаатай үүрэг чиглэлийг албан шаардлагаар тус тус хүргүүлж, төсөв захирагч, санхүү бүртгэлийн ажилтан нарт зөвлөмж чиглэл өгсөн.

Мөн хяналт шалгалтын дүнгээр 5.8 сая төгрөгийн зөрчлийг шалгуулахаар хуулийн байгууллагад шилжүүлсэн байна. Сангийн сайдын баталсан нэгдсэн удирдамжаар цар тахлын улмаас Засгийн газраас айл өрх, албан байгууллага, аж ахуйн нэгжид цахилгаан, дулаан, хог, уур усны үнийн хөнгөлөлт үзүүлсэнтэй холбоотой хөнгөлөлт, чөлөөлөлт, үйлчилгээний төлбөрийг нэхэмжилсэн тооцоог шалгах санхүүгийн хяналт шалгалт хийгдэж эхлээд байна.

Гурав. Хууль, эрх зүйн бодлогын хүрээнд

Гамшиг осол

Аймгийн хэмжээнд 2022 оны 10 дугаар сард 8 удаагийн аюулт үзэгдэл осол тохиолдсны дотор объектын гал түймэр 2, ой, хээрийн гал түймэр 1, зам тээврийн осол 1, мал амьтны гоц халдварт мялзан өвчин 3, хүний гоц халдварт өвчин /ковид-19/ цар тахал 1 тус тус гарч дээрх гамшиг ослоос ОБГ-ын алба хаагчид 149 иргэний амь нас, 95 сая төгрөгийн өмч хөрөнгийг авран хамгаалсан байна.

Гэмт хэрэг, зөрчил

Аймгийн хэмжээнд 2022 оны эхний 10 сарын байдлаар нийт 2296 дуудлага, мэдээлэл хүлээн авснаас гэмт хэргийн шинжтэй 895, зөрчлийн шинжтэй 1401 гомдол, мэдээллийг шалгаж шийдвэрлэсэн нь өмнөх оны мөн үеэс 570 буюу 24.8 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Аймгийн хэмжээнд 2022 оны эхний 10 сарын байдлаар аймгийн хэмжээнд 340 холбогдогчтой 1.4 тэр бум төгрөгийн хохиролтой 462 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад нийт хэрэг 136 буюу 29.4 хувь, холбогдогч нь 71 буюу 20.8 хувиар өссөн байна. Нийт үйлдэгдсэн гэмт хэргийн 126 буюу 27.2 хувийг хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг, 156 буюу 33.7 хувийг хулгайлах төрлийн гэмт хэрэг, 49 буюу 10.6 хувийг хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэрэг, 24 буюу 5.1 хувь нь авто ослын гэмт хэрэг, 53 буюу 11.4 хувийг залилах гэмт хэрэг тус тус эзэлж байна.

Шүүхийн шинжилгээний алба 2022 оны 10 дугаар сард шүүх эмнэлгийн шинжилгээ 52, криминалистикийн шинжилгээ 6, хэргийн газрын үзлэгээр илрүүлж бэхжүүлсэн ул мөр, эд мөрийн баримт 117, тусгай шинжилгээ 24-г хийсэн байна.

Улсын бүртгэлийн үйлчилгээ

2022 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн байдлаар дараах бүртгэлийг тус тус хийж гүйцэтгэсэн байна.

Иргэний бүртгэл

Төрсний бүртгэл – 150

Овог эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр өөрчилсний бүртгэл - 5

Эцэг /эх/ тогтоосны бүртгэл - 3

Гэрлэсний бүртгэл - 30

Гэрлэлт дуусгавар болсны бүртгэл - 5

Үрчилсний бүртгэл - 1

Нас барсны бүртгэл – 30

Шинээр иргэний үнэмлэх олгосон – 133

Дахин олгосон – 52

Солиулсан - 231

Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл

Газар өмчлөх эрхийн анхны бүртгэл – 17

Үл хөдлөх хөрөнгө өмчлөх эрхийн анхны бүртгэл – 25

Шинээр бүртгүүлсэн орон сууцны бүртгэл - 28

Худалдах худалдан авах гэрээ – 64

Бэлэглэлийн гэрээ – 8

Барьцааны эрхийн бүртгэл – 139

Өв залгамжлал – 4

Хамтран өмчлөгч өөрчлөгдөх – 7

Лавлагаа – 4

Бусад эрхийн бүртгэл – 10

Хууль хяналтын байгууллагад нийт 60 лавлагааг гарган хүргүүлсэн. Дээрхи бүртгэлүүдийг хийж үйлчилгээний хөлс 2641912 төгрөг, тэмдэгтийн хураамжид 366123 төгрөг, үл хөдлөх хөрөнгө худалдсанаас оруулсан татварын орлого 16384536 төгрөгийг тус тус улсыг төсөвт төвлөрүүлсэн байна.

Хуулийн этгээдийн улсын бүртгэл

Шинээр бүртгүүлсэн – 16

Өөрчлөлт – 20

Тамганы хяналтын дугаар олгосон – 24

Дөрөв. Боловсрол, соёл, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын бодлогын хүрээнд

Боловсрол

Аймгийн хэмжээнд 2022-2023 оны хичээлийн жилд ерөнхий боловсролын сургуульд 19600, хүүхдийн цэцэрлэгт 6700, нийт 26300 суралцагч боловсрол эзэмшиж байна.

Энэ хичээлийн жилд Архангай аймагт 2047 хүүхэд 1-р ангид элсэн орсон. Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын салбарын 2022-2023 оны хичээлийн жилийн зорилгыг “Хүүхдийн нийгэм, сэтгэл зүй, танин мэдэхүйн хөгжлийг дэмжих, боловсрол эзэмшихэд тулгарч буй бэрхшээлийг арилгаж, сурах тэгш боломж бүрдүүлэх, хувь хүний онцлогт нийцүүлэн сургалт, үйл ажиллагааг чанар, үр дүнтэй зохион байгуулах, хамтран суралцах арга барилыг сургалтад нэвтрүүлэх” хэмээн тодорхойлж ажиллаж байгаа бөгөөд боловсролын байгууллагуудын үйл ажиллагаа хэвийн, жигд явагдаж байна.

2022 онд боловсролын салбарт улсын болон орон нутгийн төсвийн 41.5 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар нийт 26 барилга, өргөтгөл, их засварын ажил, үүнд багшийн хөгжил, судалгааны арга зүйн төв-1, сургууль-8, дотуур байр-1, цэцэрлэг-7 нийт 17 барилгыг улсын төсвийн 40,4 тэрбум төгрөгийн хөрөнгөөр шинээр барих, сургууль- 3, спорт заал-4, цэцэрлэг-1 нийт 8 барилгад улсын төсвийн 200,0 сая, орон нутгийн хөгжлийн сангийн 902,0 сая, нийт 1,1 тэрбум төгрөгийн их засварын ажлыг тус тус гүйцэтгэж байгаагаас 10 дугаар сарын 27-ны өдрийн байдлаар барилга, засварын ажлын гүйцэтгэл дунджаар **68.4** хувьтай байна.

Эрүүл мэнд

Аймгийн хэмжээнд 2022 оны эхний 9 сард нийт 252,487 үзлэг хийснээс 79,357 буюу 31.4 хувийг урьдчилан сэргийлэх үзлэг эзэлж байна. Нийт үзлэгийн 45 хувь нь сумын эрүүл мэндийн төвүүдэд, 36 хувь нь аймгийн Нэгдсэн эмнэлэгт, 17 хувь нь өрхийн эрүүл мэндийн төвүүдэд, 2 хувь нь хувийн эмнэлгүүдэд бүртгэгдсэн байна.

Хүн амын нас баралтын 371 тохиолдол бүртгэгдсэн. Нас баралтын шалтгаанд зүрх судасны эрхтэн тогтолцооны өвчлөлийн нас баралт 147/39,6%, хорт хавдарын нас баралт 87/23.4%, осол гэмтэл, гадны шалтгаант нас баралт 71/19%/ тохиолдлоор тэргүүлэх шалтгаан болж байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад нийт нас баралт 7 тохиолдлоор буурсан.

0-5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл аймгийн хэмжээнд 17 тохиолдол гарсан бөгөөд 0-1 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл 13 тохиолдол байна.

Аймгийн хэмжээнд 2022 оны эхний 9 сарын байдлаар цочмог халдварт өвчний нийт 5360 тохиолдол бүртгэгдсэнээс коронавируст халдварын нийт 5084 тохиолдол бүртгэгдсэн.

2022 оны 05 дугаар сарын 01-нээс улсын хэмжээнд эхэлсэн хүн амыг зонхилон тохиолдох Халдварт болон Халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх эрт илрүүлэг үзлэг шинжилгээнд хамруулах ажлын хүрээнд Архангай аймагт 2022 оны 10 дугаар сарын 27-ны байдлаар 0-5 насны 2443, 6-17 насны 4146, 18-30 насны 1180, 31-45 насны 818, 46-60 насны 509, 61-ээс дээш насны 109, нийт 9205 иргэн үзлэгт хамрагдсанаас эрүүл илэрсэн иргэн 4115, эрсдэлтэй илэрсэн иргэн 416, өвчтэй илэрсэн иргэн өвчтэй илэрсэн 4769 байна.

Эрдэнэмандал сумын Эрүүл мэндийн төвийн шинэ барилга ашиглалтад орлоо.

Оюутны эрүүл мэндийг дэмжих сарын аяны хүрээнд Багшийн сургуулийн 100 гаруй оюутанд эрүүл мэндийн сургалт хийж, урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах үйл ажиллагааг эхлүүлж, 26 оюутныг хамруулаад байна.

Улирлын томуугийн эсрэг 12270 хүн тун вакциныг татан авч, эрүүл мэндийн байгууллагуудад хуваарилан 0-5 насны хүүхэд, 65-аас дээш насныхан, архаг суурь өвчтэй иргэдийг дархлаажуулах ажлыг эхлүүлсэн.

Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлын нөхцөл байдал

/2022.10.27-ны өдрийн байдлаар/

Батлагдсан тохиолдол:

Нийт батлагдсан тохиолдол /2021-2022 он/- 17947

Үүнээс: 2022 онд – 5084

Сүүлийн 7 хоногт батлагдсан тохиолдол – 0 (10 сарын 20-27)

Нас баралт:

Нийт нас баралт – 42

Үүнээс: 2021 онд – 39

2022 онд – 3

Түргэвчилсэн шинжилгээ:

Нийт хийсэн түргэвчилсэн шинжилгээ /2021-2022 он/ - 53732

Үүнээс 2022 онд - 10575

Сүүлийн 7 хоногт хийсэн шинжилгээ – 99

Үүнээс эерэг – 0

ПСР шинжилгээ:

Нийт хийсэн ПСР шинжилгээ /2021-2022 он/ - 89494

Үүнээс 2022 онд - 11982

Сүүлийн 7 хоногт хийсэн шинжилгээ – 15

Үүнээс эерэг – 0

Вакцинжуулалт:

1-р тунд 60893 хүн буюу 87.23 % /12-оос дээш нас/

2-р тунд 57627 хүн буюу 82.80% /12-оос дээш нас/

3-р тунд 27334 хүн буюу 48.88 % /18-аас дээш нас/

4-р тунд 2516 хүн буюу 5,01% /18-аас дээш нас/

Хөдөлмөр эрхлэлт

2022 оны 10 дугаар сарын байдлаар Хөдөлмөрийн зах зээлийн нэгдсэн сан LMIS программд ажил идэвхтэй хайгч 1154 иргэн бүртгэлтэй байгаагаас 519 эмэгтэй. Шинэ ажлын байр 537, үүнээс байнгын ажлын байр 307, улирлын ажлын байр 22, түр ажлын байр 208 байна.

Тав. Хөдөө аж ахуйн бодлогын хүрээнд

Мал аж ахуй

2022-2023 онд аймгийн 19 сумын 101 багийн 3.7 сая га бэлчээрт 8202 хот айлд 19.7 мянган малчин, мал бүхий өрхийн 6.1 сая орчим толгой малыг өвөлжүүлж, хаваржуулах бэлтгэл ажлыг хангалаа.

Аймгийн хэмжээнд 14.3 мянган ширхэг бодын, 18.9 мянган ширхэг богийн, нийт 33.3 мянган ширхэг малын хашаа шаардлагатайгаас 31.2 мянган ширхэг буюу 94.1 хувийн хангамжтай байна. 2022 онд 89 ширхэг бодын, 97 ширхэг богийн хашааг тус тус шинээр барьж ашиглалтад оруулсан.

Малчдын түвшинд 80 мянган тн өвс, 1300 тн гар бэлтгэхээс 68.7 мянган тн өвс, 860 тн ногоон тэжээл, 535 тн үйлдвэрийн тэжээл, 1097 тн гар тэжээл, 7 тн дарш, ногооны хаягдал, 3755.5 тн давс, хужир шүүг бэлтгэн хадлан бэлтгэл 90,3 хувьтай байна.

Аймаг сумын аюулгүйн нөөцөд 1670 тн өвс, 620 тн гар тэжээл бэлтгэхээс 1279.5 тн өвс, 402.3 тн ногоон тэжээл, гар тэжээл бэлтгэн бэлтгэл аюулгүй нөөц бэлтгэл аймгийн хувьд 70.8 хувьтай байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 17 сумын 88 багийн 880 өрхөд 400 га талбайд 74.8 тн хошуу будаа тарих үрийн дэмжлэг үзүүлсэн бөгөөд Жаргалант, Эрдэнэмандал, Төвшрүүлэх, Цэцэрлэг сумдын малчид өвөлжөө, хаваржааныхаа хөл бууцанд, бусад 13 сум Техникийн дундын төвөөр нэгдсэн талбайд тариалалт хийлгэж, нийт 400 га талбайгаас 600 орчим тн ногоон тэжээл хураан авсан.

2022 онд Эрдэнэмандал сум малын тоо толгойн татварын орлогын хөрөнгөөр 118,56 м³ өвс тэжээлийн агуулах, НҮБ-ын Хөдөө аж ахуйг хөгжүүлэх олон улсын сангийн "Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил" төслийн 50 хувийн хөрөнгө, сумын Орон нутгийн хөгжлийн сангийн 50 хувийн хөрөнгө оруулалтаар Хангай сум 0.3 га талбай бүхий бетон угсармал хашаатай 50 тн тэжээл хадгалах агуулах, 5000 ш өвс хураах багтаамжтай саравчийг барьж тус тус ашиглалтад оруулсан.

Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын 2022 оны 09 дүгээр сарын 08-ны өдрийн "Шүлхий өвчнөөс сэргийлэх намрын нэгдсэн дархлаажуулалтын ажлыг зохион байгуулах тухай" А/191 дүгээр тушаал, Архангай аймгийн Засаг даргын 2022 оны 09 дүгээр сарын 16-ны өдрийн "Дархлаажуулалтын ажлыг зохион байгуулах тухай" А/674 дүгээр захирамжийн хүрээнд 17241 өрхийн 933833 үхэр, 1245 гахай, нийт 935078 мал, амьтныг дархлаажуулалтад хамруулахаас 13957 өрхийн, 907527 үхэр, 1195 гахай, нийт 908722 мал, амьтан хамруулж, дархлаажуулалтын ажил 97.3 хувьтай явагдаж байна.

Бог малын гоц халдварт мялзан өвчний дархлаажуулалтад нийт 42 мянган тун вакцин хүлээн авч Жаргалант, Хайрхан, Цэцэрлэг сумдад дархлаажуулалтын ажлыг зохион байгуулж байгаа бөгөөд дархлаажуулалтын ажил 72 хувьтай явагдаж байна.

Газар тариалан

2022 онд газар тариалангийн үйлдвэрлэл аймгийн хэмжээнд төмс 275 га, хүнсний ногоо 166 га, жимс жимсгэнэ 84 га, малын тэжээл 4100 га, тосны ургамал 600 га талбайд тариалахаар төлөвлөөд байгаа бөгөөд өнөөдрийн байдлаар улаанбуудай 10453 га-д тариалж 130%, арвай 70 га-д тариалж 70%, хошуу будаа 340 га-д тариалж 170%, тосны ургамал 1225 га-д, малын тэжээл 2440 га-д, хүнсний ногоо 126.3 га-д, төмс 263.2 га-д, жимс, жимсгэнэ 84.7 га-д тариалж, нийт 15003 га талбайд тариалалт хийсэн байна. Төлөвлөсөн хэмжээнээс 11 хувиар нэмэгдсэн.

Ургац хураалтын урьдчилсан балансаар га-гаас 12 цн буюу 12544 тн улаанбуудай, 492 тн хошуу будаа, га-гаас 21 цн буюу 5125 тн малын тэжээл, 613 тн тосны ургамал, га-гаас 90 цн буюу 2368.8 тн төмс, 1010.4 тн хүнсний ногоо, нийт 22153.2 тн ургац хураан авахаар тооцсон.

Үр тариа 4626 га талбайгаас 5345 тн, төмс 242 га-аас 1631 тн, хүнсний ногоо 108 га-аас 927 тн, тэжээлийн ургамал 1879 га-ас 4089 тн, тосны ургамал 350 га-аас 195 тн, улаанбуудайнаас тэжээлд 700 га талбай шилжиж 1750 тн тэжээл хураан авч боосон бөгөөд аймгийн хэмжээнд хураалт 48 хувьтай явагдаж байна.

Зургаа. Байгаль орчин, үйлдвэрлэл үйлчилгээ, дэд бүтцийн салбарын бодлогын хүрээнд

Ногоон байгууламж, мод тарих

Архангай аймаг нь “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд 2021-2030 оныг хүртэлх хугацаанд 20 сая мод тарьж ургуулах төлөвлөгөөг боловсруулах ажлын хэсгийг аймгийн Засаг даргын 2021 оны А/713 дугаар захирамжаар байгуулан аймгийн хэмжээнд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг боловсруулж хэрэгжүүлэн ажиллаж байна. “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд хавар, намрын тарилтаар 19 сумын хэмжээнд 497,016 ширхэг мод, бут сөөгийг үрээр болон тарьц суулгацаар тарьж усалгаа, арчилгааны ажлыг гүйцэтгээд байна. Энэ жилийн мод тарих ажлын хүрээнд төв суурин газрын ногоон байгууламжийг нэмэгдүүлэх зорилгоор сумдын төвийн хашаа, хамгаалалттай сад, цэцэрлэгт хүрээлэнг засаж сэлбэн сайжруулж мод тарих чиглэлийг сумдын Засаг дарга нарт өгч хамтран ажиллаж байна. “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнийг хэрэгжүүлэх, уур амьсгалын өөрчлөлт, цөлжилт, элсний нүүлтийг зогсоох, иргэдийн ажиллаж амьдарч буй орчныг ногоон байгууламжтай болгох зорилгоор нэг иргэн нэг мод уриалгыг өрнүүлж иргэд аж ахуйн нэгж, байгууллагыг мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж байна. Мөн ойн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.2 дахь хэсэгт заасны дагуу ойн мэргэжлийн байгууллагууд бэлтгэсэн модныхоо тоо хэмжээнээс хамааруулан ойжуулалтын ажлыг өөрсдийн хөрөнгөөр хийж гүйцэтгэж байна.

2022 онд “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд аймгийн хэмжээнд нийт 478.0 мянган ширхэг модыг тарихаар төлөвлөснөөс 497.0 мянган ширхэг модыг тарьж ажлын гүйцэтгэл 100 хувьтай байна. Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Монгол Улсын их сургуультай хамтран хэрэгжүүлж буй “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд сургагч багш бэлтгэх сургалтын хээрийн дадлага сургуулилалт хийж “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд бүс нутгийн онцлогт тохирсон модны зүйлийг сонгох, үр түүж бэлтгэх, тарьц суулгац ургуулах, мод тарьж ургуулах, арчлан хамгаалах технологийн талаар нэгдсэн мэдлэг өгөн иргэд, аж ахуйн нэгж, байгууллагад зааж сургах, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллах “Сургагч багш”-ийг бэлтгэх энэхүү сургалтад 19 сумын 57 иргэн хамрагдлаа.

Улсын төсвийн 198.8 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар “Мастер Эрчим” ХХК нь Эрдэнэбулган сумын 2-р багийн ногоон байгууламж байгуулах ажил явагдаж байна.

Булган, Цэнхэр сумын ойд арчилгаа, цэвэрлэгээ явуулах тусгай зөвшөөрөлтэй 13 ойн мэргэжлийн байгууллага хамтран Эрдэнэбулган сумын улсын чанартай авто зам дагуу 600 м² талбайг хашиж (6м*100м), 70 гаруй ширхэг шинэсний суулгац тарьж, усалж арчиллаа.

Хог хаягдлын менежмент

Тэрхийн цагаан нуурын хойд, урд хэсэг Чулуутын хавцал, Хөх нуур, хойд Тамир голын эх, Суварга хайрхан Ширдэгийн гол, Ихтамир сумын Хойд тамирын гол, Өндөр-Улаан сумын Бэлхи багт орших Чулуутын гол, Тарвуу, Тамирын голын голдирол дагуух хог хаягдал болон нийтийн эзэмшлийн зам талбай, голын голдирол, улсын болон орон нутгийн чанартай зам дагуух хог хаягдал цэвэрлэх ажлыг 354 аж ахуй нэгж байгууллагын 8503 ажилтан албан хаагч, иргэд оролцож, 361 машин техник ашиглан 1832.8 га талбай, 122 км голын голдирол, 548 км улсын болон орон нутгийн чанартай зам цэвэрлэн 1520.3 тн хог хаягдал, малын сэг сэм ачиж зайлуулж төвлөрсөн хогийн цэгт хаяаад байна. Хог цэвэрлэгээний ажил үргэлжиж байна.

Чулуут сумын хогийн цэгийг гуравдугаар зэрэглэлийн хог хаягдлын төвлөрсөн цэгийн стандартын шаардлагад нийцүүлэх ажлыг “Газрын гагнаас” ХХК гүйцэтгэж хүлээн авах комисс ажлыг хүлээж аваад байна.

Хангай сумын хогийн цэгийн хэмжээг бууруулах, хог хаягдлыг түрж дарж булшлах ажлын гүйцэтгэл 80 хувьтай явагдаж байна, Хотонт, Хангай сумд хогийн цэгийг камержуулсан. “Монголын унаган байгалийн хүлцэл тогтворжилтийг хангах нь” төслийн 45 сая, сумын орон нутгийн хөгжлийн сангийн 45 сая, нийт 90 сая төгрөгний санхүүжилтээр Хайрхан суманд “Хог хаягдлын менежмент, дахин боловсруулалтын санал санаачилгыг дэмжих нь төсөл” хэрэгжиж ажлын гүйцэтгэл 80 хувьтай байна.

Энэхүү төслийн хүрээнд ангилдаг хогийн сав 6 ширхэг, хоёрдогч түүхий эд авах автомат машин 1 ширхэг, албан байгууллагын ангилдаг хогийн сав 6 ширхэг, хог шахагч машин 1 ширхэг, хог шатаах зуух 1 ширхэг, 10 айлын хашааны тохижилт жорлон, хогийн савыг шийдвэрлэж хог хаягдлыг ангилан ялгах, эдийн засгийн эргэлтэд оруулах боломж бүрдэнэ.

Намрын нийтийн хог цэвэрлэгээнд Эрдэнэбулган сумын нийтийн эзэмшлийн зам талбай, голын голдирол, улсын болон орон нутгийн чанартай зам дагуух хог хаягдал цэвэрлэх ажлыг 90 гаруй аж ахуй нэгж, байгууллагын 1340 гаруй албан хаагч 54тн хог хаягдлыг цэвэрлэж, ачиж зайлуулсан байна.

Хүнсний хангамж

Аймгийн хэмжээнд хүнсний чиглэлийн 74 үйлдвэр, цех 239 ажилтантайгаар үйл ажиллагаа явуулж байна. Дотоодын үйлдвэрлэлээр аймгийн хүн амын хүнсний хэрэгцээний 40.9 мянган тн мах бэлтгэж 100%, 35.3 сая литр сүү бэлтгэж 100%, 0.32 мянган тн гурил бэлтгэж 12.5%, 2.58 мянган тн гурилан бүтээгдэхүүн бэлтгэж 42%, 2.2 мянган тн төмс бэлтгэж 57%, 1.3 мянган тн хүнсний ногоо бэлтгэж 23%, 0.025 мянган тн жимс, жимсгэнэ бэлтгэж 0.5%, 0.05 мянган тн өндөг бэлтгэж 10 хувийг тус тус хангаж байна.

19 сумын хүнсний хангамж, нөөцийн мэдээг хүнсний нөөцийн цахим системд мэдээлж байгаа бөгөөд сүүлийн 7 хоногийн судалгаагаар малын мах 136.8 тн буюу 9 хоног, гурил 263 тн буюу 34 хоног, гоймон 27.3 тн буюу 2 хоног, будаа 88.95 тн буюу 23 хоног, сахар 69.8 тн буюу 28 хоног, ургамлын тос 30.01 тн буюу 17 хоног, давс 27.9 тн буюу 70 хоног, ундны ус 48.3 мянган литр буюу 1 хоног, хуурай сүү 9.06 тн буюу 6 хоног, төмс 49 тн буюу 5 хоног, хүнсний ногоо 24.7 тн буюу 1 хоног, өндөг 1.65 тн буюу 1 хоногийн нөөцтэй байна.

Хоршоо, жижиг дунд үйлдвэр

Хүнс, хөдөө аж ахуйн хөнгөн үйлдвэрийн сайдын 2022 оны А/168 дугаар тушаалаар батлагдсан “Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, дамжуулан зээлдүүлэх, эргэн төлүүлэх, хяналт тавих журам”-ын дагуу жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчийн төслийг хүлээн авах үйл ажиллагааг 2022 оны 06 дугаар сарын 06-ны өдрөөс орон даяар нэгэн зэрэг авч эхэлсэн. 2022 оны 06 дугаар сарын 06-ны өдрөөс өглөөний 08:30 цагаас 2022 оны 07 сарын 07-ны өдрийн өглөөний 08:30 цаг хүртэл цахимаар хүлээн авсан бөгөөд нийт 10 төсөл бүртгүүлснээс 3 төсөл хүчингүй болж хасагдсан 7 төслийг шалгахад 3 төсөл иж бүрдэл дутуу шалтгаанаар хасагдаж 4 төсөлд программын тооцооллыг оруулж шалгаруулалт явагдсан.

2022 оны 09 сарын 05, 06-ны өдрүүдэд жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас ажлын хэсэг ирж нарийвчилсан судалгаа хийхэд шалгарсан 4 төслийн 30 хувь болон барьцаа хөрөнгийг газар дээр очиж танилцан үнэлгээ өгөхөд 1 төсөл нь барьцаа хөрөнгө болон үйл ажиллагаа жигдрээгүй байсан тул төслийг буцааж, аймгийн Төсөл сонгон шалгаруулах дэд хороо 2022 оны 10 дугаар сарын 04-ний өдөр хуралдаж 3 төсөлд 550.000.000 (таван зуун тавин сая) төгрөгийн зээлийг батласан.

Барилга байгууламж, дэд бүтэц, орон сууц,

“Эвт-Уул” ХХК Тариат сумын Мөрөн багийн Тасгалын төмөр бетонон гүүр /36 у/м/, Хайрхан сумын Хануйн голын төмөр бетонон гүүр /109,15 у/м/ барих ажлыг гүйцэтгэж байна.

Өндөр-Улаан сумын Донгой багаас Чулуут сумын төв хүртэлх 65,8 км хатуу хучилттай авто замын ажлыг “ЗЗБ” ХХК, “Саруул харгуй” ХХК, “Эвт Уул” ХХК-иуд хамтран 2022-2024 онд түншлэлээр гүйцэтгэж байна.

2022 оны 10 дугаар сард барилга захиалагчийн албанаас 8 барилгын ажилд захиалагчийн үе шатны ажлыг гүйцэтгэсэн.

2022 онд аймгийн хэмжээнд дараах орон сууц баригдаж байна. Үүнд:

д/д	Захиалагч иргэн, аж ахуйн нэгж	Гүйцэтгэгч аж ахуйн нэгж	Давхар	Айлын тоо	Барилгын ажлын гүйцэтгэл
1	Иргэн Сүхээ	“Тамир таун” ХХК	4	12	100%
2	Иргэн Б.Үүрцайх	“Цагаан Сүмбэр” ХХК	5	50	95%
3	Иргэн Ж.Нэргүй	“Гурван Тамир” ХХК	5	15	30%
4	Иргэн Б.Бадрал	“Гэрэгэ” ХХК	5	17	90%
5	Иргэн Н.Баянмөнх	“Сайхан тэрх” ХХК	5	15	90%
6	Иргэн Бямбаа	“Идэрживаа” ХХК	6	60	100%
7	Иргэн Н.Номин	“Тайгер дизайн” ХХК	4	12	30%
8	Иргэн Манлай	“Марч контсракшн” ХХК	6	42	98%
9	Иргэн Манлай	“Марч контсракшн” ХХК	7	49	50%
10	Иргэн Д.Батбаяр	“Класик булдинг” ХХК	9	128	0%
11	Иргэн Н.Баянмөнх	“Сайхан тэрх” ХХК	9	54	55%
12	Иргэн Нямдорж		9	-	40%
13	Иргэн Д.Чулуунбаатар	“Эсгэл” ХХК	5	18	85%
14	Иргэн Б.Шинэбаатар		5	15	20%
15	Иргэн Бямбаа	“Идэрживаа” ХХК	5	40	70%
16	Иргэн Бямбаа	“Өлзий тээл” ХХК	5	40	70%

АРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

-----oOo-----